

ДОРНОГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Дорноговь аймгийн Төрийн Аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн,
үр ашиг



2018 он

АГУУЛГА

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>Дорноговь аймгийн Төрийн аудитын газар</p> <p>Дарга, Тэргүүлэх аудитор Ч.Ариунаа</p> <p>Аудитын менежер Ц.Лүндэгмаа</p> <p>Аудитор П.Энхбаяр</p> <p>2017 оны 6 дугаар сар</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7052-2734, 7052-3020 дугаарын утас, 7052-2734 дугаарын факсаар харилцана уу</p> <p>ХАЯГ: Орон нутгийн өмчийн 3- р байр</p>	<p><i>Товчилсон үгийн тайлбар</i>3</p> <p><i>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</i>.....5</p> <p>БҮЛЭГ А. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хууль журмын холбогдох заалтыг мөрдөөгүй байна.</p> <p>А.1 Хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө орон нутгийн хэрэгцээ шаардлагыг харгалзаагүй байна.-----6-7</p> <p>БҮЛЭГ Б. Хяналт сул байгаагаас хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна.</p> <p>Б.1 Захиалагч чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс зураг төсөл, зохиогчийн хяналтын зардлыг ТББ-д тусгуулсан гүйцэтгүүлсэн байна.....8-9</p> <p>Б.2 Зураг төсөл боловсруулах, зохиогчийн хяналтыг зохион байгуулах ажлууд дүрмийн дагуу хийгдээгүй байна.9-11</p> <p>Б.3 Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй байна.12-13</p> <p>Б.4 Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж иржээ.....13-13</p> <p>Бүлэг 4. Дүгнэлт-----14</p> <p>Бүлэг 4. Зөвлөмж-----15</p> <p>Холбогдох байгууллагын санал-----</p> <p>Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар-----</p>
--	--

Товчилсон үгийн тайлбар

БСШУСС	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын сайд
ТАХ	Төсөл арга хэмжээ
БНБД	Барилгын норм ба дүрэм
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа болон ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЕБС	Ерөнхи йболовсролын сургууль
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ТББ	Тендерийн баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагтай компани
БТСГ	Биеийн тамир спортын газар
ЕБ	Ерөнхий боловсролын
ЗГ	Засгийн газар
АЗДТГ	Аймгийн Засаг даргын тамгын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУ	Монгол улсын

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, аудитын нэр

Аудитын нэр: “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”

Аудитын код: ДГА/2018/02-ГА

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг МУЕА-ын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” сэдэвт аудитын төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт: “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитын дэд зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх,

Хамарсан хүрээ: Аудитад улсын төсвөөс 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын 14 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг болон эдгээр төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэс, ГХБХБГ, Орон нутгийн өмчийн газар болон ашиглагч байгууллагуудыг хамруулав.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэдээ Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглан, шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, худалдан авалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын судалгаа, үр дүнгийн мэдээллийг боловсрууллаа.

ҮАГ-аас ирүүлсэн судалгааны маягтын дагуу орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн аудитын судалгаа, холбогдох мэдээллийг ҮАГ-т 2018 оны 4 дүгээр сарын 20-ны дотор хүргүүлж, нэгтгүүлсэн.

Орон нутагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зураг төсөв, гүйцэтгэлийг нарийвчлан шалгах зорилгоор аудитад зөвлөх шинжээчийг татан оролцууллаа.

ҮАГ-аас томилогдсон хөндлөнгийн шинжээчийн баг Сайншанд сумын 50 ортой төрөх эмнэлгийн барилгын чанар байдал, төсөвт өртөгт иж бүрэн дүгнэлт, Хатанбулаг спорт цогцолборын барилгын чанар байдалд дүгнэлт, Замын үүдийн 960 хүүхдийн сургуулийн барилгын төсөвт өртөг нэмэгдсэн шалтгаан тодруулахаар ажиллаж байна.

Аудитын хугацаа: Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2018 оны 01 дүгээр сарын 15-нд эхлүүлж, аудитын талбарын ажлыг 2018 оны 03 дугаар сарын 12-ноос 4 дүгээр сарын 10-ны өдрүүдэд гүйцэтгэсэн ба аудитын судалгаа, холбогдох мэдээллийг 4 дүгээр сарын 20-нд, тайланг 6 дугаар сарын 08-нд бичиж холбогдох байгууллагад хүргүүлэв.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн: Аудитыг Дорноговь аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Ариунаа удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Ц.Лүндэгмаа хэрэгжүүлж, аудитор П.Энхбаяр гүйцэтгэв.

Үндсэн мэдээлэл: МУ-ын 2017 оны Төсвийн тухай хууль 2016 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан бөгөөд уг хуульд 2017 оны 4 дүгээр сарын 14-нд болон 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулжээ.

Сайдын багцаас тус аймагт 2.4 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр захиалагчийн эрх шилжүүлэн, 1.5 тэр бум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Орон нутагт хэрэгжүүлсэн улсын төсвийн хөрөнгийн санхүүжилтийн 27 хувийг боловсролын салбарт, 67 хувийг эрүүл мэндийн салбарт, 4 хувийг бусад салбарт зарцуулахаар тус тус хуваарилжээ.

Бүлэг А

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хууль журмын холбогдох заалтыг мөрдөөгүй байна.

А.1 Хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө орон нутгийн хэрэгцээ шаардлагыг харгалзаагүй байна.

А.1.1 Орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг бодитой төлөвлөөгүй байна.

А.1.1.1 МУ-ын 2017 оны Төсвийн тухай хуулийн дагуу салбар сайдын багцаас тус аймагт 2.4 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

А.1.1.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг судлаагүй төлөвлөсөн байна. Тухайлбал: батлагдсан төсөл арга хэмжээ хэрэгжээгүй, зарим төсөл арга хэмжээний төсөвт тусгагдсан ажилбарыг хэрэгжүүлэх шаардлагагүйгээс тоо хэмжээ, нэрийг өөрчилж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- БСШУССайдын багцаас Айраг сумын сургуульд 25.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бохирын септик систем /сав/ суурилуулахаар төлөвлөн орон нутагт эрхийг шилжүүлжээ. Бохир усны төвийн шугамд холбогдсон тус сургуульд бохирын септик суурилуулах шаардлагагүйгээс батлагдсан төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.
- БСШУССайдын багцаас Биеийн тамир спортын газрын спорт заалны дээврийн засварын ажилд 79.2 сая төгрөгийг төлөвлөж, салхивчийн шинэчлэл, дээврийн ажил, орчны зам талбайн тохижилтын ажлыг гүйцэтгүүлэхээр эрх шилжүүлэн ХААА-г зохион байгуулжээ. Гүйцэтгэгч дээрх ажлуудаас дээврийн засварын ажлыг 16.3 сая төгрөгөөр төсөвлөсөн нь норм дүрмийн дагуу хийхэд хүрэлцэхгүй, үр ашиггүй хөрөнгө оруулалт болох тухай санал гаргаж, зориулалтыг өөрчлөн дотор заслын ажил хийхээр болсон.
- Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн засварын ажлын төсөвт өртөгт тусгагдсан 5.5 сая төгрөгийн ажлыг ашиглагч байгууллага 2016 онд өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн тул төлөвлөсөн ажлын зориулалтыг өөрчилсөн.

А.1.2 Зураг төсөлгүй төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлуулсан байна.

А.1.2.1 Орон нутагт эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээнүүдээс зураг төсөл нь батлагдаагүй 8 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹, Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3² дэх заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

¹Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана гэж заасныг зөрчиж байна.

² Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3-д Барилга байгууламжийн техникийн нөхцөл, зураг төсөл боловсруулах, барилгын ажлын зөвшөөрлийг энэ хуулийн 22, 23, 26 дугаар зүйлд заасны дагуу авч, түүнд заасан нөхцөлийг биелүүлэх;

1. Замын-Үүд сумын 1-р цэцэрлэгийн барилгын гадна фасад, дээврийн засвар, төсөвт өртөг 36.1 сая төгрөг,
2. Зүүнбаян багийн 7-р цэцэрлэгийн барилгын засвар, төсөвт өртөг 90.0 сая төгрөг,
3. Сайншанд сумын 6-р цэцэрлэгийн барилгын засвар, төсөвт өртөг 73.97 сая төгрөг
4. Мандах ЕБС-ын барилгын дээвэр, гадна фасад, спорт залны шалны засвар, төсөвт өртөг 33.43 сая төгрөг
5. Даланжаргалан сумын эрүүл мэндийн төвийн халаалтын тогооны засвар, төсөвт өртөг 28.8 сая төгрөг
6. Сайхандулаан сумын ЭМТ-ийн уурын зуух, яндан, тогооны засвар төсөвт өртөг 17.94 сая төгрөг
7. Алтанширээ сумын сургуулийн дотуур байр, спорт залны халаалтын тогооны барилгын шинэчлэл засварын ажил, төсөвт өртөг 79.20 сая төгрөг
8. Номын сангийн барилгын дээврийн засварын ажил, төсөвт өртөг 37.49 сая төг

А.1.2.2 Дээрх төсөл арга хэмжээнүүдийн төсөвт өртөг нь Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм БНБД 81-94-12³ дагуу боловсруулсан ажлын зурагт тооцсон төсөв дээр үндэслэгдэн батлагдаагүйгээс зураг төслийн үнийг тендерийн бичиг баримтад тусгуулахаар төлөвлөжээ.

А.1.2.3. ТЕЗ-д хугацаа алдаж эрх шилжүүлснээс тендер оройтон зарлагдаж ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.8⁴-дэх заалт зөрчигдсөн байна. Энэ нь засварын ажлыг хүйтний улиралд гүйцэтгэх, батлагдсан санхүүжилтийг авахын тулд хэрэгжээгүй ажилд баримт бүрдүүлэн олгох зөрчилд хүргэсэн байна. Тухайлбал

- ЭМС-ын 2017 оны А/425 тоот тушаалаар Дорноговь аймгийн Даланжаргалан сумын эрүүл мэндийн төвийн уурын зуух, яндан, тогооны засварын ажлын эрхийг 2017 оны 11-р сарын 14-нд шилжүүлсэн.
- ЭМС-ын 2017 оны А/425 тоот тушаалаар Сайхандулаан сумын эрүүл мэндийн төвийн дотор халаалтын системийн шинэчлэлийн ажлын эрхийг 2017 оны 11-р сарын 14-нд шилжүүлсэн.

³Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм БНБД 81-94-12-ийн 3.3.1-д Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний хүчин чадлын төсөвт өртөг нь мөрдөгдөж байгаа норм дүрмийн дагуу боловсруулсан ажлын зургийн дагуу тооцсон төсөв дээр үндэслэгдсэн өртгийн үзүүлэлт байна.

⁴46.1.8-д барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх.

Бүлэг Б

Хяналт сул байгаагаас хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна.

Б.1 Захиалагч чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс зураг төсөл, зохиогчийн хяналтын зардлыг ТББ-д тусгуулсан гүйцэтгүүлсэн байна.

Б.1.1 Зураг төсөлгүй батлагдсан ТАХ-ний зураг төслийг ТББ-д тусгуулан гүйцэтгүүлсэн байна.

Б.1.1.1 ТББ-т зураг төсөлгүй батлагдсан ТАХ-ний зураг төслийн үнэ, зохиогчийн хяналтын зардлыг тусгаж ирүүлэхийг заажээ.

- Сайншанд сумын ЕБ-ын 3-р сургуулийн барилгын гадна фасадын засварын ажлын зураг төслийн үнэ 2300.0 мянган төгрөг
- Замын-Үүд сумын 1-р цэцэрлэгийн барилгын гадна фасад, дээвэр засварын ажлын зураг төслийн үнэ 123.9 мянган төгрөг
- Алтанширээ сумын сургуулийн дотуур байр, спорт залны халаалтын тогооны барилгын шинэчлэл засварын ажлын зураг төслийн үнэ 1400.0 мянган төгрөг
- Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн засварын ажлын зураг төслийн үнэ 1280.0 мянган төгрөг
- БТСпорт заалны дээврийн засварын ажлын зураг төслийн үнэ 850.0 мянган төгрөг
- Сайншанд сумын 6.7-р цэцэрлэгийн засварын ажлууд нь зураг төсөлгүй байхад зохиогчийн хяналтын зардал нийт 1405.8 мянган төгрөг тусгаж ирүүлэхийг зааж, уг зардлаар зураг төсөл хийлгүүлсэн.

Б.1.1.2 Захиалагч Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3⁵ заасан чиг үүргийг хэрэгжүүлээгүйгээс гүйцэтгэгч компани зургийн байгууллагатай зураг төсөл боловсруулах гэрээ байгуулсан нь төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах боломжийг алдагдуулах, хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт орхигдоход хүрч байна.

- Зүүнбаян багийн 7-р цэцэрлэгийн барилгын засварын ажлын гүйцэтгэгч Болор Аграмба ХХК нь Сайншанд сумын 6,7-р цэцэрлэгийн засварын ажлын зураг төсөл боловсруулах гэрээг зургийн Дотлайн ХХК-тай байгуулжээ. Аграмба ХХК-д зураг төслийн үнэ 1423775 төгрөгийг шилжүүлсэн бөгөөд боловсруулсан зурагт нь дээвэр засах, шал өөрчлөх зураг дутуу хийгдсэн байна.
- БТСГ-ын барилгын дээврийн засварын ажлын гүйцэтгэгч Тобэм ХХК нь Биеийн тамирын заалны агаар сэлгэлтийн засварын ажлын зураг төсөл боловсруулах гэрээг зургийн Бьюлдингс техноложу ХХК-тай байгуулжээ. Тобэм ХХК-д зураг төслийн үнэ 850000 төгрөгийг шилжүүлсэн бөгөөд боловсруулсан зурагт нь дотор заслын ажлын зураг дутуу хийгдсэн байна.
- Замын-Үүд сумын 1-р цэцэрлэгийн барилгын гадна фасад, дээврийн засварын ажлын гүйцэтгэгч Оточ буян ХХК-д тус төсөл арга хэмжээний зураг төслийг хийлгүүлэхээр 123900 төгрөгийн санхүүжилтийг олгосон боловч ажлын зураг хийгдээгүй байна.

⁵ Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3-д “Барилгын ажлын захиалагч барилга байгууламжийн техникийн нөхцөл, зураг төсөл боловсруулах, барилгын ажлын зөвшөөрлийг энэ хуульд заасны дагуу авч, түүнд заасан нөхцөлийг биелүүлэх чиг үүрэгтэй”

Б.1.1.3 ТБОНӨХБАҮХАТХуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 5-аас доошгүй хоногийн дараа гэрээ байгуулна гэж заасан. Гэтэл Сайншанд сумын 6-р цэцэрлэгийн барилгын засварын ажлын гүйцэтгэгч Хорго групп ХХК-д гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг 2017 оны 6 дугаар сарын 29 ний өдөр олгож, 1 өдрийн дараа буюу 6 дугаар сарын 30-ны өдөр гэрээ байгуулсан байна.

Эрх олгох шийдвэрийг хянуулах хугацаа, боломжийг шалгараагүй оролцогчдод олгоогүй байгуулсан уг гэрээг ТБОНӨХБАҮХАТХуулийн 42 дугаар зүйлд⁶ зааснаар хүчин төгөлдөр бус гэрээ гэж үзэхээр байна.

Б.1.2 Зарим төсөл, арга хэмжээний тендерийн урилгыг системд зарлан үр дүнг нийтэд мэдээлсэн байна.

Б.1.2.1 Орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 12 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 4, харьцуулалтын аргаар 2, шууд гэрээ байгуулах аргаар 6 ажил үйлчилгээг зохион байгуулж, тендерийн урилгыг www.tender.gov.mn системд зарлан, тендер шалгаруулалтын үр дүнг нийтэлсэн байна.

Б.2 Зураг төсөл боловсруулах, зохиогчийн хяналтыг зохион байгуулах ажлууд дүрмийн дагуу хийгдээгүй байна.

Б.2.1 Төсөл арга хэмжээний зураг, төслийг барилгын норм ба дүрмийн дагуу боловсруулаагүй байна.

Б.2.1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээний зураг төслийг барилгын ажлын явцад хийлгэсэн бөгөөд хэмжилтийн зурагт хаалга, цонхны болон өрөө тасалгаа, давхарын өргөн, өндрийн хэмжээ, гадна ханын зузаан, шалны өөрчлөлт хийх хэсэг тодорхойгүй, зарим ажилбаруудыг зураг төсөлгүй гүйцэтгэсэн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Зүүнбаян багийн 7-р цэцэрлэгийн барилгын засварын хэмжилтийн зурагт: өрөө тасалгаа, давхарын өндөр, цонх хаалганы өндөр, гадна дотор ханын зузаан тусгаж өгөөгүй, шинээр солих шалны хэсэг тодорхойгүй, дээврийн зураг байхгүй,
- БТСГ-ын барилгын дээврийн засварын хэмжилтийн зурагт дотор заслын ажлын зураг байхгүй,
- Замын-Үүд сумын 1-р цэцэрлэгийн барилгын гадна фасад, дээврийн засварын ажлын зураг хийгдээгүй.
- Номын сангийн барилгын дээврийн засварын ажлын зураг байхгүй
- Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн засварын ажлын хэмжилтийн зурагт: өрөө тасалгаа, давхар, цонх хаалганы өндрийн хэмжээ байхгүй, гадна дотор ханын зузаан тусгаж өгөөгүй, шалны өөрчлөлт хийх хэсэг тодорхойгүй
- Сайншанд сумын 6-р цэцэрлэгийн барилгын засварын хэмжилтийн зурагт: өрөө тасалгаа, давхарын өндөр, цонх хаалганы өндөр, гадна дотор ханын зузаан тусгаж өгөөгүй, шинээр солих шалны тодорхойлолт байхгүй байна.

Б.2.2 Төсөвт өртгийн нэмэгдэл зардлын нормыг дүрмийн дагуу тооцоогүй байна.

⁶ ТБОНӨХБАҮХАТХуулийн 42.1.Худалдан авах гэрээг дараахь тохиолдолд хүчин төгөлдөр бус гэж үзнэ, 42.1.2. захиалагч энэ хуулийн 27, 28, 29 дүгээр зүйлд заасан журмыг зөрчиж гэрээ байгуулсан:

Б.2.2.1 Үнэлгээний хороо тендерт оролцогч компаниудын ирүүлсэн төсөвт өртөг Барилгын төсөв зохиох дүрэм БНБД 81-95-12⁷ дагуу хийсэн эсэхийг хянаагүй байна. Тухайлбал: Барилгын засварын ажлын нэмэгдэл зардлыг үе шатны ажлын цалингаас I бүсэд 58.6 хувиар тооцохоор байтал Сайншанд сумын 3-р сургуулийн гадна засвар, Зүүнбаян багийн 7-р цэцэрлэгийн барилгын засвар, Сайншанд сумын 6-р цэцэрлэгийн засварын ажлуудын төсөвт 61 хувиар тооцсон байна.

Б.2.2.2 Биеийн тамир спортын газрын дээврийн засварын ажлыг дотор засал болгон өөрчилсөн бөгөөд засварын ажлын төсөв, зураг төсөлд Барилгын тухай хуулийн 40.1.17⁸-д заасны дагуу өөрчлөлт оруулж баталгаажуулаагүй байна.

Б.2.3 Барилга байгууламжийн зохиогчийн хяналтыг дүрмийн дагуу зохион байгуулж хэрэгжүүлээгүй байна.

Б.2.3.1 Барилгын тухай хуулийн 38.1.4⁹, ЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.1.4¹⁰, Барилга хот байгуулалтын сайдын 2016 оны 178 тушаалаар баталсан дүрмийн¹¹ дагуу зураг, төсөл зохиогчийн хяналтыг зохион байгуулж, хэрэгжүүлээгүй байна.

Б.2.3.2 Зураг төсөл зохиогч захиалагчтай гэрээ байгуулан зохиогчийн хяналт тавихаар дүрэмд заасан байтал ашиглагч байгууллагатай гэрээ байгуулсан байна.

- Зураг төслийн Жанжин өргөө ХХК нь Алтанширээ сумын сургуулийн дотуур байр, спорт заалны халаалтын тогооны барилгын шинэчлэл засварын ажлын явцад зохиогчийн хяналт хийх гэрээг ашиглагч байгууллагын захиралтай байгуулсан.

Б.2.3.3 Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.31-д Барилгын зураг төсөл зохиогч гэж барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах эрх бүхий хуулийн этгээдийг хэлнэ гэж заасан. Гэтэл аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн засварын ажлын зургийг тус барилгын засварын ажлын гүйцэтгэгч Айсуй хөгжил ХХК-ийн инженер хийсэн бөгөөд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Б.2.3.4 Сайншанд сумын 6,7-р цэцэрлэгийн засварын ажлын төсөвт өртөгт зохиогчийн хяналтын зардалыг тусгуулан 7-р цэцэрлэгийн засварын ажлын гүйцэтгэгч Болор аграмба ХХК-д зураг төслийг нь хийлгүүлэхээр санхүүжилтийг олгожээ.

Б.3 Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй байна.

Б.3.1 Зарим төсөл арга хэмжээг зураг төсөлгүй гүйцэтгэсэн байна.

⁷ Барилгын төсөв зохиох БНБД 81-95-12 дугаартай нормын хавсралт 7-д Барилгын засварын ажлын нэмэгдэл зардлыг үе шатны ажлын цалингаас (ҮАЦ)-аас, I бүсэд 58.6%-иар тооцно. Энэ нормын хавсралт 10-д Сайншанд хот I бүсэд хамаарна гэж заажээ.

⁸ Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.17-д Барилгын ажлын явцад зураг төсөл өөрчлөгдсөн бол гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж баталгаажуулах;

⁹ Барилгын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.4-д Зохиогчийн техникийн хяналтыг барилгын ажлын үе шатанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэх

¹⁰ЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.1.4-д Захиалагч барилгын ажилд зохиогчийн хяналт тавих гэрээг зураг төсөл зохиогчтой байгуулах

¹¹ Барилга хот байгуулалтын сайдын 2016 оны 178 тушаалаар баталсан Барилгын ажилд зохиогчийн хяналт тавих дүрэм /БНБД 11-04-16/-ийн 3.1-д Зураг төсөл зохиогч барилгын ажлын захиалагчтай гэрээ байгуулан барилгын ажилд зохиогчийн хяналт тавина.

Б.3.1.1 Барилгын тухай хуулийн 40.2-д “Барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно” гэж заасан байтал орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн дараах ТАХ-г зураг төсөлгүй гүйцэтгэсэн байна.

- Номын сангийн барилгын дээврийн засварын ажил
- Мандах сумын сургуулийн барилгын дээвэр, гадна фасад, спорт залны шалны засварын ажил
- Замын-Үүд сумын 1-р цэцэрлэгийн барилгын гадна фасад, дээврийн засварын ажил
- Даланжаргалан сумын ЭМТ-ийн уурын зуух, яндан тогоо, шинэчлэх ажил
- Сайхандулаан сумын ЭМТ-ийн дотор халаалтын системн шинэчлэх ажил

Б.3.1.2 Барилга байгууламж ашиглалт оруулах комисс ЗГ-ын 2017 оны 69 тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4.1¹², 4.4¹³, 4.7¹⁴ заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна. Орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн барилгын засварын ажлыг техникийн тодохойлолт, зураг төсөл, төсвийн дагуу хийж гүйцэтгээгүй, ажил эхлээгүй байхад комиссын актаар хүлээн авсан байна.

- Сайншанд сумын 6-р цэцэрлэг засварын ажлаар хийгдэх /60.48 м2/ гантгиг чулуун тавцанг гантгиг өнгөтэй хуванцар бэлдэцээр сольсон.
- Замын-Үүд сумын 1-р цэцэрлэгийн барилгын гадна фасад, дээвэр засварын ажлаар хийгдэх барилгын цоколь хэсгийг /56.8 м2/ хиймэл хавтанцараар өнгөлөх ажил хийгдээгүй орхигдсон.
- Спорт заалны дээврийн засварын ажлаар хийгдэх БТСГ-ын гадна талбайд суурилуулах 1 толгойтой төмөр шонтой 2 ш лед гэрэлтүүлэг хийгдээгүй.
- Даланжаргалан сумын ЭМТ-ийн халаалтын тогооны шинэчлэлийн ажлаар хийгдэх 0.4м3 эзэлхүүнтэй 120.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тэлэлтийн савны оронд 1ш пошик, 2м3 эзэлхүүнтэй 1200.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй нөөц усны савны оронд 2ш пошик орлуулж тавьсан, 12м урт 506.4 мянган төгрөгийн 2ш утааны яндангийн оронд 4.6м урттай 2ш хуучин яндан, 140.0 мянган төгрөгийн гар насосны оронд хуучин насосыг эргүүлж тавьсан.
- Сайхандулаан сумын ЭМТ-ийн дотор халаалтын системн шинэчлэлтийн ажил, Даланжаргалан сумын ЭМТ-ийн халаалтын тогооны шинэчлэлийн ажлууд эхлээгүй байхад ашиглалтад оруулах комиссын акт үйлдэн санхүүжилтийг бүрэн олгосон боловч Даланжаргалан сумын ЭМТ-ийн халаалтын тогоо, яндан шинэчлэх ажил өнөөг хүртэл дуусаагүй байна.

Б.3.1.2 Даланжаргалан, Сайхандулаан сумдын эрүүл мэндийн төвийн халаалтын шугам, уурын зуухны тогоог ашиглалтад оруулах үйл ажиллагааг дүрмийн дагуу дахин зохион байгуулах, дутуу орхисон ажлыг гүйцээх, залруулахыг ГХБХБГ-т хариуцуулж холбогдох гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх тухай албан шаардлагыг аудитын явцад хүргүүлээ.

¹² ЗГ-ын 2017 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан дүрмийн 4.1-д Барилга байгууламж ашиглалтад оруулах комисс (цаашид “комисс” гэх) дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

¹³ ЗГ-ын 2017 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан дүрмийн 4.4-д Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж, комиссын гишүүд хариуцсан асуудал тус бүрээр санал гаргана. Комиссын нийт гишүүдийн саналыг үндэслэн комиссын дүгнэлтийг гаргах бөгөөд уг дүгнэлтийг комиссын нийт гишүүд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

¹⁴ ЗГ-ын 2017 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан дүрмийн 4.7-д Комиссын гишүүд үүрэг, даалгавар бүрээр гүйцэтгэсэн ажлын биелэлтэд урьдчилан үнэлэлт, дүгнэлт өгсөн байх бөгөөд комиссын хуралдаанаар үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн хэлэлцэж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

Б.4 Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж иржээ

Б.4.1 Захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээний заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

Б.4.1.1 Аймгийн ЗДТГ нь захиалагчийн хяналтыг ГХБХБ-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлдэг боловч дүгнэж ажилладаггүйгээс гэрээний холбогдох заалтууд хэрэгждэггүй байна. Тухайлбал: гүйцэтгэгчээс ирүүлсэн үе шатны ажлыг хянаж баталгаажуулаагүй байхад санхүүжилтийг олгох, гэрээний дагуу ажил хийгдээгүй байхад албан бичгээр мэдээлдэггүй, техник хяналтын ажлын тайлан гаргах гэх мэт ажлуудын хэрэгжилт хангалтгүй байна.

Б.4.1.2 “Захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээ”-ний холбогдох заалтуудыг мөрдөөгүйгээс гүйцэтгэгчийн гаргасан алдаа зөрчилд хариуцлага тооцох ажил орхигдсон байна.

Б.4.1.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа зарим ТАХ-ний гүйцэтгэлд Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.3¹⁵ дахь заалтыг зөрчиж санхүүжилт олгосон, захиалагчийн барилгын ажлын үе шатны хяналт хангалтгүй, гэрээний хэрэгжилтийг дүгнэж, санхүүжилтийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй хариуцлага тооцоогүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулж байна. Тухайлбал:

Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй хариуцлага тооцоогүй.

- Замын-Үүд сумын 1-р цэцэрлэгийн барилгын гадна фасад, дээвэр засварын ажлын гүйцэтгэгч Оточбуян ХХК гэрээний хугацаа 20 хоног хэтэрсэн
- Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн засварын ажлын гүйцэтгэгч Айсуй хөгжил ХХК гэрээний хугацаа 19 хоног хэтэрсэн
- Сайншанд сумын ЕБ-ын 3-р сургуулийн барилгын гадна фасад засварын ажлын гүйцэтгэгч Өгөөмөрөн шанд ХХК гэрээний хугацаа 17 хоног хэтэрсэн
- Замын-Үүд сумын 1-р цэцэрлэгийн барилгын гадна фасад, дээвэр засварын ажлын гүйцэтгэгч Оточ буян ХХК гэрээний хугацаа 17 хоног хэтэрсэн
- Алтанширээ сумын сургуулийн дотуур байр, спорт залны халаалтын тогооны барилгын шинэчлэл засварын ажлын гүйцэтгэгч Айсуй хөгжил ХХК гэрээний хугацаа 36 хоног тус тус хэтэрсэн байхад хариуцлага тооцож ажиллаагүй.

Дутуу ажилд хариуцлага тооцоогүй:

- Даланжаргалан сумын ЭМТ-ийн халаалтын тогооны шинэчлэлийн ажил дуусаагүй байхад хариуцлага тооцоогүй

Гүйцэтгэл гараагүй байхад санхүүжилт олгосон:

- Сайншанд 6-р цэцэрлэгийн засварын ажлын 40.0 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэл гараагүй байхад олгосон.
- Сайхандулаан, Даланжаргалан сумын тогооны ажил эхлээгүй байхад хуурамч гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгосон

4.1.4 Захиалагч зураг төсөл зохиогч болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүрмийн дагуу дүгнэж хариуцлага тооцон ажиллаагүй байна. .

¹⁵ Захиалагч байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан норм, норматив, дүрэм болон тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын ажлын төлөвлөгөөг үндэслэн ажил нэг бүрээр нь тулган шалгаж баталгаажуулна.

4.1.5 Зохиогч болон захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээний талуудын хариуцлага сул байгаагаас хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна.

Даланжаргалан сумын ЭМТ-ийн халаалтын тогооны шинэчлэлийн ажлаар хийсэн яндан, тэлэлтийн савны зураг



Б.4.2 Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээ хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байна.

Б.4.2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээ хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй, байна. Тухайлбал:

- Номын сангийн 2-р давхарын өрөө, тасалгаануудын халаах хэрэгсэл халахгүй байгаа шалтгааныг олж төлөвлөөгүйгээс шинэчилсэн ч догогдол арилаагүй,
- Мандах сумын спорт залны шалыг зориулалтын будгаар будаагүйгээс хүүхдүүд хичээллэх явцад хальтирдаг,
- Зүүнбаян багийн 7-р цэцэрлэгийн засварын ажлаар сольсон зарим цонх чанарын шаардлага хангахгүйгээс шороо тоос ордог.

Б.4.2.2 Даланжаргалан сумын ЭМТ-ийн уурын зуух яндан тогооны засварын ажлын төсөвт зуухны яндангийн тоо хэмжээ буруу өгөгдснөөс галалгааны үед утаа алдан, өрөө тасалгаа утаа тортог болж, эмнэлгийн ажилчид дахин засварласан. Мөн гүйцэтгэгч системийн усыг бүрэн юүлээгүйгээс засварын үед зарим өрөөний халаах хэрэгсэл, шугам сүлжээ хөлдөж хагарсан байсныг засуулахаар гүйцэтгэгчтэй тохиролцсон боловч хийгдээгүй байна.

ЭМГ-ын даргын тоот албан бичгээр халаалт жигдрэхгүй, дулаанаар хангаж чадахгүй байгаа нь эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нөлөөлж байгаа талаар болон засварын ажлын гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийлгэх хүсэлтийг аймгийн Засаг даргат удаа дараа хүргүүлсэн боловч өнөөг хүртэл шийдвэрлээгүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг бодитой төлөвлөөгүй байна.

Зураг төсөл нь батлагдаагүй ТАХ-ний зураг төслийн үнийг ТББ-д тусгуулан хэрэгжүүлсэн бөгөөд зураг, төсөл, нэмэгдэл зардлыг барилгын норм ба дүрмийн дагуу боловсруулаагүй, зарим ТАХ-г зураг төсөлгүй гүйцэтгэсэн байна.

ЭМС-ын багцаас худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг оройтуулж шилжүүлснээс шалтгаалж төсөл арга хэмжээ тайлант хугацаанд хэрэгжих боломжгүй болсон байна.

Барилга байгууламжийн зохиогчийн хяналтыг дүрмийн дагуу хэрэгжүүлээгүй, захиалагч гэрээний заалтуудыг мөрдөж, дүгнэж ажилладаггүйгээс гүйцэтгэгчийн гаргасан алдаа зөрчилд хариуцлага тооцох ажил орхигдсон байна.

Зарим засварын ажил эхлээгүй байхад комиссын актаар хүлээн авч, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Аудитаар нийт 628.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 53.9 сая төгрөгийн 2 албан шаардлага бичлээ.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин танаа:

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж хэрэгжсэн ТАХ-ний ашиглалтыг сайжруулах
2. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх, хариуцлага тооцох

Аймгийн ЗДТГ-ын дарга Б.Ганзориг танаа:

1. ТАХ-ний гүйцэтгэлийн үе шатны хяналтыг хэрэгжүүлэх, чанартай гүйцэтгүүлэх, батлагдсан хугацаанд ашиглалтад хүлээн авахад анхаарч ажиллах
2. Зураг төсөл зохиогч болон захиалагчийн хяналт гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүрмийн дагуу дүгнэж, хариуцлага тооцон ажиллах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛ

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Утас/факс: (705) 2-31-40

2018-06-14 № 256

танай _____-ны № _____-т

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Ч.АРИУНАА ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн “Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.


Аймгийн ИТХ-аас Төсвийн хуулийг хэрэгжүүлж ажиллахад онцгой анхаарч байгаа бөгөөд тайланд тусгасан зөвлөмжийг хүлээн авч байна.

Тайлангийн төсөлд өгөх санал байхгүй бөгөөд цаашид орон нутгийн төсвийн төлөвлөлтөд хөрөнгийн үр ашигтай, тооцоо судалгаатай, хяналтын төсөв, зураг төсөл нь бүрэн арга хэмжээг тусгаж байхын тулд зарим ажлуудыг зохион байгуулахаар ажиллаж байна. Үүнд:

- Дараа оны төсвийн төсөл боловсруулах удирдамж, төсвийн төслийг төлөөлөгчдөд цаг тухайд нь танилцуулах, тэдэнд мэдлэг ойлголт өгөх
- Төсвийн төсөл боловсруулах үе шатуудад төлөөлөгчид болон холбогдох байгууллагуудаас шаардлага хангасан төсөл арга хэмжээг тусгах талаар мэдээлэл өгөх
- Төсөв батлах хуралдаан болохоос өмнө төлөөлөгчдийг хороодоор урьдчилан ажиллуулан, төсөл арга хэмжээнд тавигдах шаардлагуудыг хангасан эсэхээр дүгнэлт гаргуулах
- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид санал шаардлага тавих

Түүнчлэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018.06.07-ны өдрийн “Хяналт шалгалтын ажил зохион байгуулах тухай” 46 дугаар тогтоолоор хороодын хяналт шалгалтын ажлын хэсэг гарч улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж буй төсөл арга хэмжээнд хөндлөнгийн хяналт шалгалтын ажил хийн газар дээр үзэж шалгаж ажиллахаар шийдвэрлэсэн. Энэ ажлын хүрээнд танай байгууллагын аудитын тайланг мөн баримт болгон ашиглаж холбогдох санал дүгнэлтийг гарган ажиллах болно.

НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



Н.ХОНГОРЗУЛ



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон,

Утас/факс: (705) 2-30-03

E-mail: dornogobi_mgl@yahoo.com

2018.06.13 № 3/1146

танай 2018.06.14-ны № 1-6/468 -т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын тайланд өгөх саналыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт ...6..... хуудастай.

ДАРГА

Б.ГАНЗОРИГ



АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/16

Дорноговь аймаг, Сайншанд сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйлийн 15.1.12, 15.2.2, 19.3.3, Монгол улсын Ерөнхий аудиторын 2003 оны 53 дугаар тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам", 2017 оны 188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамж, аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн "Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр ашиг, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан, төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитаар өгөгдсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ц.Лүндэгмаа/-д үүрэг болгосугай.
3. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Замын-Үүд сумын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

9825883